

## ЗӨВЛӨМЖ

2023 оны 03 дугаар сарын 31

Арвайхээр

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тухай

### Нэг. Зорилго

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### Хоёр. Үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг (газар, хэлтэс, алба)-ийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ дараах баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

- Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ
- Шударга байдлын түвшний үнэлгээ
- Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт
- Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээ:
- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:
- Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт зэрэг 13 үзүүлэлтийг хамруулсан болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3-т заасан арга зүйгээр дээрх 13 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулга авах, хамааралтай баримт бичиг болон статистик мэдээллийн дүнтэй харьцуулалт хийсэн болно. Мөн 2021 оны үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 5 үзүүлэлт нийт үнэлгээний 50 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 3 үзүүлэлт 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 5 үзүүлэлт 20 хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ болох 1 үзүүлэлтийг 10 хувиар тус тус тооцсон болно. Эдгээр үзүүлэлтээс Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Шударга байдлын түвшний үнэлгээг Хууль, эрх зүйн хэлтсээс авч ашигласан болно.

Аймгийн Засаг даргын баталсан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх удирдамжид тусгагдсан үзүүлэлтүүдээс Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв Шударга байдлын түвшний үнэлгээний тайланг ирүүлээгүй.

Мөн Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон үйл ажиллагаа явуулж байгаа тул цаашид холбогдох мэдээ, тайланг журмын дагуу ирүүлж байхад анхаарах

### **Гурав: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ**

#### **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ тухайн байгууллагаас ирүүлсэн тайлангийн ирцийн үнэлгээ, чанарын үнэлгээ гэсэн 2 үзүүлэлтийн дунджаар үнэлэв. Агентлагуудын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг алдаа дутагдал байгаа тул цаашид дараах асуудлуудад анхаарах нь зүйтэй байна. Үүнд:

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эзэнжүүлж, шаардлагатай шийдвэрт хувийн хэрэг нээж, хувийн хэргийн бүрдлийг ханган, баяжилт хийж ажиллах;

-Тайлангийн чанарыг сайжруулах, тайланг нэгтгэх, дүгнэх ур чадварт албан хаагч бүрийг сургах, чадавхжуулах;

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан ([unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn))-д тайлагнаж байгаатай холбогдуулан хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа заалтуудын бодит үр дүнг сайжруулахад санал, санаачилга гарган хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай уялдаатай ажиллаж гүйцэтгэлийг чанаржуулах, бодит үр дүнг нэмэгдүүлэх;

-Хэрэгжилт тогтмолжсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, нэг удаагийн шинжтэй шийдвэрийн заалтуудыг тухай бүр бүртгэл хяналтаас хасаж байх;

-Гүйцэтгэл сайжруулах болон байгууллагын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлэх;

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг журамд заасан хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь ирүүлж байх:

#### **Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр:**

-Байгууллагуудын хувьд тухайн арга хэмжээний хэрэгжилт ямар түвшинд байсан нь тухайн онд хэрхэн яаж сайжирсан талаарх мэдээлэл байхгүй, нэгтгэн дүгнээгүй тодорхой бус, үйл явцыг тоочиж тайлагнах дутагдалтай байна.

Иймд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үйл явцыг бус шалгуур үзүүлэлтийн дагуу бодит үр дүнг дүгнэн тайлагнаж хэвших шаардлагатай.

**Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

-Үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн байгууллагад хамааралтай зорилт, арга хэмжээг эзэнжүүлэх, үйл ажиллагааны чиглэлээр нь байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих арга зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаагүй.

-Тайлангийн хэрэгжилтийг дүгнэхдээ суурь түвшинг зорилтот түвшинтэй харьцуулах, бодит үр дүнг тооцоход анхаараагүй.

-Байгууллагуудын хувьд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт ямар хугацаанд хэрэгжих, хэрэгжүүлэх нэгж тасаг, санхүүжилтийн эх үүсвэр ихэнх арга хэмжээнд тусгагдаагүй, үнэлгээ хийхэд өмнөх оны хүрэх түвшингээс ахисан эсэх нь тодорхойгүй байх дутагдлууд байсаар байна. Тайлагналт хэт ерөнхий байгаагаас тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бодлогын ямар өөрчлөлт гарсан, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг дүгнэх боломжийг бууруулж байна.

**Дөрөв: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ**

**Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:**

-Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ нь байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгагдаагүй, тусгагдсан тохиолдолд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон дутагдалтай.

-Байгууллагынхаа албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв, товч тодорхой тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.8-т зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаана гэж заасан бөгөөд энэ нь үйл явцыг бус гол үр дүнг тайлагнах шаардлагатай байгааг илэрхийлсэн байна.)

**Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:**

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин оновчгүй тодорхойлогдсоноос үүдэн хэрэгжилт, үр дүн уялдаа муутай, оновчгүй, ойлгомжгүй байх дутагдлууд давтагдсаар байгаа нь албан хаагчдын албан бичгийн боловсруулалтын чадвар, ойлголт мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой байна.

Гүйцэтгэлийн зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангах шаардлагыг бүрэн хангаж ажиллах нь зүйтэй.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа салбарын стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдтэй сайтар уялдуулж, арга хэмжээний санхүүжилт, шаардагдах хөрөнгийг бодитой төлөвлөх.

Гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлагнахдаа гадаад хүчин зүйлээс шалтгаалж хэрэгжээгүй, эсвэл хэрэгжилт нь хойшилсон арга хэмжээг журмын дагуу заавал үнэлэх, хэрэгжээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдах.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу гадаад хүчин зүйлээс шалтгаалан гүйцэтгэл тасарсан, хойшилсон аливаа ажил, арга хэмжээг 0, 30, 50 хувиар үнэлэхээр тусгагдсан байгаа тул цаашид гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон бусад нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний зорилтыг хангах чиглэлээр шинэ арга зам, боломжийг эрэлхийлэх, ялангуяа цахим хэлбэрийг бүрэн ашиглаж, хэрэгжилтийг хангахад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

“Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ”-г хэрэгжүүлэх зорилгоор тухайн албан хаагч гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо дараах арга зүйг мөрдлөг болгоно. Үүнд:

-Албан тушаалын зорилго, зорилтод үндэслэн албан хаагчийн гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг томъёолох;

-Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан ижил нэршилтэй, ижил утгатай, ижил агуулга бүхий зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох;

-Байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг бусад нэгж, эсхүл өөрийн нэгжийн албан хаагчтай хамтран хэрэгжүүлэхгүй тохиолдолд тухайн албан хаагч уг арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлтийг өөрчлөхгүйгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

-Байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг бусад нэгж, эсхүл өөрийн нэгжийн албан хаагчтай хамтран хэрэгжүүлэх болсон тохиолдолд тухайн албан хаагч арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлтийг дангаараа хэрэгжүүлж болохуйц байдлаар нарийвчлан тодорхойлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

-Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай байхаар тодорхойлох;

-Арга хэмжээний гол үр дүнг харуулсан 1-2 шалгуур үзүүлэлт сонгох, шаардлагатай тохиолдолд чанарын шалгуур үзүүлэлт ашиглах боломжтой ч аль болох үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлт сонгох;

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хугацааны төлөвлөлтийг жилээр бус улирлаар төлөвлөж, бодлого зохицуулалтын хүрээний гол гол арга хэмжээний төлөвлөлтүүдийг хийдэг байх

-Албан хаагчийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төсөв тавигдсан арга хэмжээнүүд байгаа бөгөөд гүйцэтгэл үр дүнд тухайн төсвийн гүйцэтгэлийг тусгахгүй байх нийтлэг алдаа гарч байна.

-Арга хэмжээг оновчгүй тодорхойлсон, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байх шаардлагыг хангаагүй, суурь түвшин тавигдаагүй, зоритот түвшинг ойлгомжгүй тодорхойлсон, үнэлгээг буруу томъёолсон, үнэлгээний хүснэгтийг буруу ашигласан зэрэг дутагдлыг дахин гаргахгүй байх.

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хувьд стратегийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээ гэж задарч томъёолдогдсон байгааг анхаарах. Мөн зорилт, арга хэмжээ тус бүрд шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлсон байхыг анхаарах.

#### **Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:**

-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль болон уг хуулийг дагаж гарсан бусад эрх зүйн актад нийцүүлэн, албан хаагчдын саналыг тусган боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах

-Хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа дунд хугацаанд болон тухайн жилд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд тодорхой тусгаж тайлагнахад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

#### **Тав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ**

##### **Байгууллагын ил тод байдлын үнэлгээ:**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийг хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийг баталсан бөгөөд хүснэгтийн хүрээнд журмын 6.7-д заасны дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг баримтлан дүгнэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны цахим сайтын хөтлөлт сайн, мэдээ мэдээлэл, тайланг тогтмол бичмэл болон зурган хэлбэрээр ойлгомжтой байдлаар оруулж, тогтмол мэдээллээ шинэчилж ажилладаг давуу талтай байна.

Цаашид аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй мэдээлэхээр заасан мэдээллийн жагсаалтын дагуу хөтлөх, шинэчлэх, байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарыг тухайлсан албан хаагчдад хариуцуулж, хяналт тавьж ажиллах, мэдээллийн шинэчлэлтийн хугацаанд анхаарах, мэдээ, мэдээллийн агуулга, алдааг хянаж засварлахад анхаарч ажиллах шаардлагатай.

#### **Шударга байдлын түвшний үнэлгээ:**

Агентлагуудын шударга байдлын үнэлгээг байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, авлигын эсрэг үйл ажиллагааны талаар цахим сайтад байршуулсан мэдээллийн тоо, чанар гэсэн үзүүлэлтийн дундажаар үнэлэв.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд цахим сайтдаа авлигын чиглэлээр цэс нээж, тодорхой мэдээллүүдийг байршуулсан хэдий ч урд оны мэдээллээ шинэчлээгүй, үүсгэсэн цэсний нэр болон байршуулсан мэдээлэл зөрүүтэй, ач холбогдолгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан, цэс үүсгэж мэдээлэл байршуулсан боловч Авлигатай тэмцэх газрын болон шилэн данс, холбогдох яамны сайтыг шууд холбосон зэрэг зөрчил давтагдан гарсан, мэдээллийн шинэчлэл, баяжилт хангалтгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байна.

Цаашид цахим сайтад байршуулвал зохих мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол шинэчилж байх, мөн авлигын чиглэлээр өдөр тутмын хийсэн ажлуудаа тухай бүр оруулж байх шаардлагатай.

#### **Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:**

Шилэн дансанд байршуулсан мэдээллүүдээс харахад гүйлгээ гараагүй сард хоосон хүснэгт хавсаргадаг, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүрэн бичдэггүй, тайлан мэдээг улирал, хагас, бүтэн жилээр оруулах мэдээллийг оруулахгүй орхигдуулдаг зэрэг зөрчил илэрсээр байна. Нийтлэг гарч буй алдааг давтан гаргахгүй байхыг бүх шатны төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, мэдээлэл оруулах эрх бүхий албан хаагчид анхааран ажиллаж хариуцлагатай хандах шаардлагатай.

Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах

#### **Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт:**

-Зөвлөмжид тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг тайлагнасан хэдий ч гарсан зөрчил дутагдлыг хэрхэн залруулж ажилласан талаар тодорхой мэдээлэл, харьцуулсан дүгнэлт хийгдэхгүй байна.

-Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, дээд шатны байгууллагын өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад нэгжийн үйл ажиллагааг чиглүүлэх;

-Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх;

-Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичиг стандарт (MNS 5140:2021)-ын хэрэгжилтийг хангаж ажиллах. Тухайлбал: Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулж мөрдөх, хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас, удирдамж гэх мэт баримт бичгийг стандартын шаардлагад нийцүүлэх, байгууллагын

архивт албан хаагчдаас баримтыг бүрэн бүрдэлтэй, хугацаанд нь шилжүүлэн авч хэвших, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх.

**Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээ:**

Хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээг Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дүн гэсэн 4 үзүүлэлтийн ирц, чанарын үнэлгээний дунджаар үнэлсэн бөгөөд хугацаатай мэдээ тайланг хугацаанд ирүүлдэггүй, тайлангийн чанар хангалтгүй байгаа зэргээс шалтгаалж хангалтгүй үнэлэгдэж байгааг анхаарч, цаашид дээрх мэдээ, тайланг хугацаанд нь аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд ирүүлж байхыг анхаарч ажиллах нь зүйтэй байна.

**Зургаа: Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:**

**Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт:**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр хавсралтаар “Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг баталсан бөгөөд хүснэгтийн хүрээнд журмын 6.2.1 дэх заалтыг баримтлан үнэлэв.

Журмын дагуу шалгуур үзүүлэлтийг тайлагнахдаа суурь түвшингээ тодорхойлоогүй эсвэл буруу тодорхойлсон, хүрэх түвшинг тодорхойлоогүй учраас хийсэн ажлыг үнэлсэн байдал бодит бус, хийсэн ажлын үр дүнг хүрэх түвшинтэйгээ харьцуулж шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй тул үнэлгээ бодит бус гарсан нийтлэг алдаа дутагдал байна.

Ногоон байгууламж

-Тарьсан модны усалгаа, арчилгааг хэрхэн шийдэж авч явах тал дээр онцгой анхаарч жил бүр тарьсан модны тооллого зохион байгуулж амьдралтын хувийг үнэн зөв тодорхойлж байх

Цахим шилжилт

-Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, E-Mongolia системд нэвтрүүлсэн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зохион байгуулалтын арга хэмжээ авч идэвх санаачилгатай ажиллах

-“Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” epr.e-mongolia.mn-ийг нэвтрүүлэх, ашиглалтыг эрчимжүүлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСЭГ